

4.1.1 АНГЛИ ХЭЛНИЙ ЭНГИЙН ӨГҮҮЛБЭРИЙН ЗАГВАР

<i>Өгүүлэгдэхүүн Subject</i>	<i>Өгүүлэхүүн verb</i>	<i>Тусгагдахуун Complement</i>	<i>Байц modifier</i>
John and I We	ate studied	a pizza "present perfect"	last night last week

Жон бид хоёр	идсэн	пицца “present perfect”	өчигдөр орой
Бид	суралцсан		өнгөрсөн долоо хоногт

4.1.1.1 ӨГҮҮЛЭГДЭХҮҮН

Өөрөө үйлдэх хэвт өгүүлбэрт өгүүлэгдэхүүн гол гишүүн байдаг. Товчдоо, хүн юм уу, юм л үйлдэгч болж байдаг. *Англи хэлэнд өгүүлбэр бүр өгүүлэгдэхүүнтэй байх ёстойг анхаарна уу.* Өгүүлбэрт өгүүлэгдэхүүн ганц тоот нэр үгээр байж болно. Жишээлбэл, Coffee is delicious. Кофе амттай байна. Milk contains calcium. Сүү кальци агуулдаг гэх мэт.

Дээрх өгүүлбэрт өгүүлэгдэхүүн тодорхой байна. Өгүүлэгдэхүүн The book is on the table. Ном ширээн дээр байна. That new red car is John's. Тэр шинэ улаан машин Жоных гэх мэтээр нэрийн бүлгээр илэрч болно. Нэрийн бүлэг гэж нэр үгээр төгссөн бүлэг үгийг хэлнэ. Гэхдээ, угтварыг тооцохгүй.

Өгүүлэгдэхүүний жишээ:

<u>We girls</u> are not going to that movie. <u>George</u> likes boats. <u>Mary, John, George, and I</u> went to a restaurant last night. <u>The weather</u> was very bad yesterday. <u>The chemistry professor</u> canceled class today. <u>The bank</u> closed at two o'clock.	<u>Охид бид</u> кинонд яваагүй байна. <u>Жорж</u> завиар явах дуртай. Өчигдөр орой <u>Мэри, Жон, Жорж, бид хэд</u> ресторанд очсон. Өчигдөр <u>цаг агаар</u> үнэхээр муу байсан. Өнөөдөр <u>химийн багш</u> хичээл ороогүй. <u>Банк</u> хоёр цагт хаасан.
---	--

It гэдэг төлөөний үг өгүүлэгдэхүүн болж болно. Нэр үгийн оронд төлөөний үгийг өгүүлэгдэхүүн болгон шууд тавьж болохгүй боловч энэ нь нэрийн бүлгийн (хэллэгийн) нэг хэсэг байна. Жишээлбэл:

<u>It</u> rains quite often here in the summer. <u>It</u> is hard to believe that he is dead.	Зун энд үргэлж бороо ордог. Түүнийг нас барсан гэдэгт итгэхэд хэцүү байна.
--	---

ГЭХ МЭТ.

Зарим өгүүлбэрт зөв хэлбэржсэн өгүүлэгдэхүүн ердийн өгүүлэгдэхүүний байранд үл тохиолдоно. Гэхдээ, зөв хэлбэржсэн өгүүлбэрт өгүүлэгдэхүүн өгүүлэхүүний дараа байрлаж, түүнийг захирдаг. *There* гэдэг үг асуултын хариу болон орж хуурмаг өгүүлэгдэхүүний үүрэг гүйцэтгэж болдог. Жишээлбэл,

There <u>was</u> a fire in that building last month. <i>verb (singular) subject (singular)</i>	Өнгөрсөн сард энэ байшинд <u>гал</u> гарсан. <i>өгүүлэгдэхүүн (ганц тоо)</i>
Was there a fire in that building last month? <i>verb subject</i>	Өнгөрсөн сард энэ байшинд <u>гал гарсан уу?</u> <i>өгүүлэхүүн</i>
There <u>were</u> many students in the room. <i>verb (plural) subject (plural)</i>	Өрөөнд <u>олон оюутан</u> байсан. <i>өгүүлэгдэхүүн (олон тоо) өгүүлэхүүн (ганц тоо)</i>
Were there many students in the room? <i>verb subject</i>	Өрөөнд <u>олон оюутан байсан уу?</u> <i>өгүүлэгдэхүүн өгүүлэхүүн</i>
	ГЭХ МЭТ.

4.1.1.2 ҮЙЛ ӨГҮҮЛЭХҮҮН

Хүүрнэх өгүүлбэрийн өгүүлэхүүн өгүүлэгдэхүүний үйл хөдлөлийг илэрхийлдэг. *Бүх өгүүлбэрт өгүүлэхүүн (үйл үг) байх ёстой.* Өгүүлэхүүнийг ганц үгээр илэрхийлж болно. Жишээлбэл,

John <u>drives</u> too fast. They <u>hate</u> spinach.	Жон жолоо барихаараа их <u>давхидаг</u> . Тэд бууцайнд дургүй. гэх мэт.
---	--

Өгүүлэхүүн үйлийн бүлгээр илэрч болно. Үйлийн бүлэг нэг юм уу хэдэн үйл үгээс бүрдэх бөгөөд тэдгээрийг гол ба дагуул гэж ангилна. Дагуул нь ямагт цөм үйл үгийн өмнө байрладаг. Жишээлбэл,

John <u>is going</u> to Miami tomorrow. (auxiliary— <i>is</i> ; main verb— <i>going</i>) Jane <u>has been reading</u> that book. (auxiliaries— <i>has, been</i> ; main verb— <i>reading</i>)	Жон маргааш Мияами <u>явна</u> . (дагуул - <i>is</i> ; гол үйл үг - <i>going</i>) Жейнь тэр номыг саяхан <u>уншсан</u> . (дагуул— <i>has, been</i> ; гол үйл үг — <i>reading</i>)
She <u>will go</u> to Boston next week. Jane <u>is</u> very tall. She <u>must have gone</u> to the bank. Joe <u>has gone</u> home. Mary <u>is watching</u> television. It <u>was raining</u> at six o'clock last night.	Тэр ирэх долоо хоногт Бостон <u>явна</u> . Жейнь <u>бол</u> маш өндөр хүн. Тэр банк <u>явсан</u> байх ёстой. Жой гэртээ <u>харьсан</u> байна. Мэри зурагт <u>үзэж</u> байна. Урд шөнө зургаан цагт <u>бороо орсон</u> .

4.1.1.3 ТУСАГДАХУУН

Тусагдахуун үйл үгийг тодотгодог. Тусагдахуун нэр үг юм уу нэрийн бүлгээр илэрдгээрээ өгүүлэгдэхүүнтэй адил. Өгүүлбэрт өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүн, тусагдахуун байх ба тусагдахуун нь ихэнхдээ үйл үгийг дагадаг, угтвараар эхэлж болохгүй, хэнийг? юу(г)? гэсэн асуултад хариулдаг. *Бүх өгүүлбэрт тусагдахуун заавал байх албагүй.* Жишээлбэл,

John bought <u>a cake</u> yesterday. (What did John buy?) Jill was driving <u>a new car</u> . (What was Jill driving?) He wants to drink <u>some water</u> . (What does he want to drink?) She saw <u>John</u> at the movies last night. (Whom did she see at the movies?) They called <u>Mary</u> yesterday. (Whom did they call yesterday?) He was smoking <u>a cigarette</u> . (What was he smoking?)	Өчигдөр Жон <u>бялуу</u> худалдаж авсан. (Жон юу худалдаж авсан бэ?) Жилл <u>шинэ машин</u> жолоодож явсан. (Жилл юу жолоодож явсан бэ?) Тэр жаахан <u>ус</u> уумаар байна гэнэ. (Тэр юу уумаар байна гэв?) Өчигдөр орой тэр <u>Жонтой</u> кинон дээр таарчээ. (Тэр хэнтэй кинон дээр таарсан бэ?) Өчигдөр тэд <u>Мэрийг</u> дуудсан. (Тэд өчигдөр хэнийг дуудсан бэ?) Тэр <u>янжуур</u> татаж байсан. (Тэр юу татаж байсан бэ?) гэх мэт.
---	--

4.1.1.4 БАЙЦ

Байц гишүүн үйлийн цаг хугацаа, орон байр, нөхцөл байдлыг заадаг. Ихэнх тохиолдолд угтвар үгийн бүлгээр илэрдэг. Угтварын бүлэг гэж угтвараар эхэлсэн, нэр үг цөмтэй бүлэг үгийг хэлдэг. *Бүх өгүүлбэрт байц байх албагүй.* Байц хэзээ? хаана? яаж? гэх мэт асуултад хариулдаг. She drove the car on the street гэх мэтээр тусагдахууны ард байц байх ёстой ч заримдаа зөрчдөг. Байц бүлэг үгээр илэрсэн бол She drove on the street the car гэх мэтээр тусагдахууныг өгүүлэхүүнээс салгаж болохгүй.

Ирээдүй цагт нэгээс илүү угтвар байвал цагийн угтвар ихэнхдээ last болдог. Угтвар нь дайвар үг юм уу дайвар үгийн хэлц байж болно. Жишээлбэл,

<u>in the morning</u> , <u>at the university</u> , <u>on the table</u> <u>last night</u> , <u>hurriedly</u> , <u>next year</u> , <u>outdoors</u> , <u>yesterday</u>	<u>өглөөгүүр</u> , <u>их сургууль дээр</u> , <u>ширээн дээр</u> <u>өчигдөр орой</u> , <u>түргэн шуурхай</u> , хойтон <u>жил</u> , <u>гадаа</u> , <u>өчигдөр</u> .
---	---

John bought a book <u>at the bookstore</u>. <i>modifier of place</i> (Where did John buy a book?) Jill was swimming <u>in the pool yesterday</u>. <i>modifier of place modifier of time</i> (Where was Jill swimming?) He was driving <u>very fast</u>. <i>modifier of manner</i> (How was he driving?) The milk is <u>in the refrigerator</u>. <i>modifier of place</i> (Where is the milk?) She drove the car <u>on Main Street</u>. <i>modifier of place</i> (Where did she drive?) We ate dinner <u>at seven o'clock</u>. <i>modifier of time</i> (When did we eat dinner?)	<u>Номын дэлгүүрээс</u> Жон ном худалдаж <i>орны байц</i> авсан. (Жон хаанаас ном худалдаж авсан бэ?) <u>Өчигдөр Жилл усан санд</u> сэлж байсан. <i>цагийн байц орны байц</i> (Өчигдөр Жилл хаана сэлж байсан бэ?) Тэр машинаар <u>их хурдан</u> явж байсан. <i>байдлын байц</i> (Тэр машинаар хэр зэрэг хурдан явж байсан бэ?) Сүү <u>хөргөгчид</u> байгаа. <i>орны байц</i> (Сүү хаана байна вэ?) Тэр <u>төв гудамжаар</u> машинаар явсан. <i>орны байц</i> (Тэр машинаар хаагуур явсан бэ?) Бид оройн <u>долоон цагт</u> хоолоо идсэн. <i>цагийн байц</i> (Бид оройн хоолоо хэзээ идсэн бэ?) гэх мэт.
---	---

1 дүгээр дасгал. Subject, Verb, Complement and Modifier

Доорхи өгүүлбэр бүрийн өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүн, тусагдахуун, байцыг ялгана. Бүх өгүүлбэрт тусагдахуун, байц байх албагүйг мартаж болохгүй.

Жишээ: Jill / is buying / a new hat / in the store. <i>subject verb phrase complement modifier of place</i> Betty / is shopping / down town. <i>subject verb phrase modifier of place</i>	Жилли /дэлгүүрээс/ шинэ малгай <i>өгүүлэгдэхүүн орны байц тусагдахуун</i> худалдан авч байна. <i>өгүүлэхүүн (үйлийн бүлэг)</i> Бэтти /хотын төвийн дэлгүүр/ хэсч явна. <i>өгүүлэгдэхүүн орны байц үйлийн бүлэг</i>
--	---

1. George is cooking dinner tonight. 2. Henry and Marcia have visited the president. 3. We can eat lunch in this restaurant today. 4. Pat should have bought gasoline yesterday.	1. Өнөө орой Жорж хоол хийсэн. 2. Хэнри, Марсиа хоёр даргындаа зочилж байна. 3. Өнөөдөр бид энэ ресторанд өдрийн хоол идэж болно.
--	--

5. Trees grow. 6. It was raining at seven o'clock this morning. 7. She opened a checking account at the bank last week. 8. Harry is washing dishes right now. 9. She opened her book. 10. Paul, William, and Mary were watching television a few minutes ago.	4. Өчигдөр Пат бензин худалдан авах байсан. 5. Мод ургадаг. 6. Өнөө өглөө долоон цагт бороо орж байсан. 7. Өнгөрсөн долоо хоногт тэр банкинд хадгаламж нээсэн. 8. Яг одоо Харри аяга, таваг угааж байна. 9. Тэр номоо дэлгэлээ. 10. Хэдхэн минутын өмнө Паул, Виллиам, Мэри гурав зурагт үзэж байсан.
--	---

Харну:

- George / is cooking / dinner / tonight.
subject verb phrase complement modifier of time
- Henry and Marcia / have visited / the president.
subject verb phrase complement
- We / can eat / lunch / in this restaurant / today.
subject verb phrase complement modifier of place modifier of time
- Pat / should have bought / gasoline / yesterday.
subject verb phrase complement modifier of time
- Trees / grow.
subject verb
- It / was raining / at seven o'clock this morning.
subject verb phrase modifier of time
- She / opened / a checking account / at the bank / last week.
subject verb complement modifier of place modifier of time
- Harry / is washing / dishes / right now.
subject verb phrase complement modifier of time
- She / opened / her book.
subject verb complement
- Paul, William, and Mary / were watching / television / a few minutes ago.
subject verb phrase complement modifier of time